



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/265

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Волейболын холбооноос манай аймагт зохион байгуулсан “Волейболын идэрчүүдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн”-ээс түүхэндээ анх удаа “Волейболын идэрчүүдийн Улсын аварга”-аар шалгарч 18 жил тасраад байсан медалийн буухиаг үргэлжлүүлсэн багийн багш дасгалжуулагч, тамирчид болон бусад аймгийн төлөөлөлд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5 200 000 төгрөг /таван сая хоёр зуун мянган/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт”-ын 5.17 дахь “Спортын аварга” хөтөлбөрөөс гаргахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/265 Ч.
02 01414

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар
сарын 03 ны өдрийн А/265 дугаар
захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д.д	Зардлын төрөл зүйл	ХНэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Хүндэтгэлийн арга хэмжээ	ш	180	20.0	3 600.0
2	Бэлэг дурсгалын эд зүйлс	ш	64	25.0	1 600.0
	ДҮН				5 200.0

-оОо-